



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/758

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйл
ийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Чэжү хотод зохион байгуулагдах олон
улсын жудо бөхийн тэмцээнд оролцох тамирчин Г.Батзоригийн замын зардалд
1500 000 төгрөг, дасгалжуулагч Г.Нямандэлэгийн замын зардалд 500 000 төгрөг
нийт 2000 000 төгрөгийг хавсралтаар баталж, дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 2000 000 төгрөг /хоёр сая/-ийг орон
нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5.17-д тусгагдсан "Спортын
аваргууд" дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын
Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын
хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
11 дүгээр сарын 14-ний өдрийн А/758
дугаар захирамжийн хавсралт



ЖУДО БӨХИЙН ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ТАМИРЧИН, БАГШ НАРЫН
ЗАМЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Овог нэр	Албан тушаал	Замын зардал /төг/
1	Г.Батзориг	тамирчин	1500 000
2	Г.Нямандэлэг	дасгалжуулагч	500 000
	НИЙТ		2000 000

-оОо-